



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2018 оны 9 дүгээр сар


Улаанбаатар
2018



1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ


Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар өсч 17.9 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 14.1 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 4.0 нэгж хувийг төгрөгийн харилцах, 3.1 нэгж хувийг валютын харилцах, хадгаламж бүрдүүлсэн байна.

Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 21.5%-иар нэмэгдсэн байна.



Нийт хадгаламжийн хэмжээ 12.2 их наяд төгрөгт хүрснээс 83.2 хувь буюу 10.2 их наяд төгрөг нь иргэдийн, 16.2 хувь буюу 2.0 их наяд төгрөг нь байгууллагын харилцах, хадгаламж байна. Нийт хадгаламжийн 22.2 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байгаагаас иргэдийн хадгаламжийн 19.1 хувийг, байгууллагын хадгаламжийн 37.3 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлжээ.

Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 21.9%-иар өсч 12.2 их наяд ₮-т хүрчээ.




Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 479.3 тэрбум төгрөгөөр өсчээ. Тодруулбал төгрөгийн болон валютын харилцахын өсөлтийг байгууллагуудын харилцахын өсөлт тайлбарлаж байгаа бол хадгаламжийн хувьд иргэдийн хадгаламж нэмэгдсэн байна.

M2 өмнөх сараас 479.3 тэрбум ₮-өөр өсөв.




M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 19.3 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн -1.4 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал M2 мөнгөний өсөлтийн 14.7 нэгж хувийг ГЦА-ын өсөлт, үлдсэн 6.8 нэгж хувийг ДЦА-ын өсөлт бүрдүүлжээ. ГЦА-ын өсөлтийг Төв Банкны ГЦА буюу гадаад валютын улсын нөөцийн өсөлт бүрүүлж байгаа бол ДЦА-ын өсөлтийг дотоод зээлийн өсөлт бүрдүүлж байна.

M2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийн ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



2. БАНКУУДЫН ЗЭЭЛ

Нийт зээлийн үлдэгдэл 16.2 их наяд ₮ -т хүрч, жилийн 21.7%-иар өсөв.



Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 21.7 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 22.3 хувиар өсч 8.1 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 19.0 хувиар өсч 8.0 их наяд төгрөгт тус тус хүрчээ.

Нийт зээлийн үлдэгдлийн 20.3 хувь буюу 3.3 их наяд төгрөг нь валютын зээл байна. Тодруулбал иргэдийн зээлийн 1.9 хувь нь, хувийн байгууллагын 39.2 хувь нь гадаад валютын зээл байна.


Тайлант сард 1801.3 тэрбум ₮-ийн зээл олгогдож, 1508.0 тэрбум ₮ эргэн төлөгдлөө.



Тайлант сард нийт шинээр олгосон зээл өмнөх сараас 153.1 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 48.3 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Олгосон зээлийн 15.7 хувь буюу 283.5 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

Өмнөх сартай харьцуулахад иргэдэд олгосон зээл 181.5 тэрбум төгрөгөөр, төлөгдсөн зээл 63.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Харин хувийн байгууллагад олгосон зээл 18.6 тэрбум төгрөгөөр, төлөгдсөн зээл 20.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Нийт чанаргүй зээлийн 82.4 хувь нь хувийн байгууллагад, 16.9 хувь нь иргэдэд ноогдож байна.



Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл 1,351.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 8.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Эдгээр зээлийн 25.2 хувь нь гадаад валютаар олгогджээ.


Чанаргүй зээлийн 23.3 хувийг боловсруулах, 17.8 хувийг уул уурхай, 14.7 хувийг барилга, 11.3 хувийг худалдааны салбарын зээл эзэлж байна.

**Чанаргүй зээл нь нийт зээлийн 8.3%,
Хугацаа хэтэрсэн зээл 6.1% байна.**



Өмнөх сартай харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 0.3 нэгж хувиар буурч 8.3 хувь болсон байна. Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сартай харьцуулахад мөн 0.3 нэгж хувиар буурсан байна. Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 83.8 хувийг, чанаргүй зээлийн 82.4 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг уул уурхай, худалдаа, боловсруулах, барилгын салбарын зээл бүрдүүлж байна.



Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 135.8 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Тайлант сард худалдааны салбарын зээл 113.8

тэрбум төгрөгөөр өссөн. Харин уул уурхайн салбар 30.7 тэрбум, барилгын салбарын зээлийн үлдэгдэл 4.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц



Тайлант сард хувийн байгууллагад 842.8 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 31.1 хувь буюу 262.0 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Худалдаа, уул уурхай, боловсруулах, барилгын салбарт дийлэнх зээл олгогдсон байна.

Иргэдийн зээлийн 40 хувийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар) бүрдүүлж байна




Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 239.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс, цалин, тэтгэврийн зээл 120.6 тэрбум төгрөг, хадгаламж барьцаалсан зээл 23.1 тэрбум төгрөг, автомашины зээл 14.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Иргэдэд олгосон зээлийн бүтэц



Тайлант сард иргэдэд 912.6 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 1.8 хувь буюу 16.9 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Иргэдэд олгосон зээлийн дийлэнхи буюу 70 хувийг цалин тэтгэвэр, хадгаламж барьцаалсан, картын болон автомашины зээл бүрдүүлсэн байна. Уул уурхай, худалдаа болон үл хөдлөх хөрөнгийн салбарт харгалзан тус бүр 6 хувь нь олгогджээ.

ЖДҮ-ийн зээлийн дийлэнх хувийг худалдаа, боловсруулах, барилгын салбарын зээл эзэлж байна.




ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 3.19 их наяд төгрөгт хүрснээс 29.4 хувийг худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 17.9 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 12.8 хувийг барилгын салбарт олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 3.8 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 12.1 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Нийт ипотекийн зээл 94246 зээлдэгчийн 4.35 их наяд төгрөг байна. Хөтөлбөрийн эх үүсвэрээр 69543 зээлдэгчид 3.4 их наяд төгрөгийн зээл олгожээ.

Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар өсчээ.




Орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 77.4 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.8 хувь нь өөрийн эх үүсвэрээр, 0.8 нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 17.4 хувь нь орон нутагт байршилтай орон сууцанд олгожээ.




Ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.5 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 22.2 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.3 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.

Нийт ипотекийн зээлийн 75.5 хувийг хөтөлбөрийн зээл эзэлж байна.



Нийт зээлийн 940.5 тэрбум төгрөг буюу 21.6 хувь нь орон нутаг дахь банкны салбараас олгосон зээл байгаа бол худалдан авсан орон сууцны байршлаар нь авч үзвэл нийт зээлийн 756.6 тэрбум төгрөг буюу 17.4 хувь нь орон нутагт ногдож байна.

Ипотекийн зээлийн 82.6 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ.



¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.8 хувь нь хэвийн, 2.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.8 хувь нь чанаргүй зээл байна.

Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 885.0 сая төгрөгөөр буурч, чанаргүй зээл 163.0 сая төгрөгөөр өссөн байна.




Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 60.2 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 37.9 хувийг хөтөлбөрийн зээл, 1.9 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.3 хувь буюу 3.9 их наяд төгрөг 80м2 хүртэлх талбайтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ.

Нийт ипотекийн зээл авсан зээлдэгчдийн 78.0 хувь нь 18-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 81.7 хувь болох 3.55 их наяд төгрөгийг бүрдүүлж байна.

Тайлант сард 50.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 28.1 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 71.9 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.

Тайлант сард шинээр 687 зээлдэгчдэд ипотекийн зээл шинээр олгожээ.



Тайлант сард ипотекийн зээлтэй нийт зээлдэгчдийн тоо 94246 байгаагийн 63.4 хувь нь сарын 2.0 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой зээлдэгчид байна.

Ипотекийн зээлийн дундаж хүү өмнөх сараас 0.5 нэгж хувиар өсчээ.



4. ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ

Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах ханш аажмаар суларсаар сарын эцсийн байдлаар 2552.1 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 3.2 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2503.3 төгрөг байсан нь өмнөх сараас нэмэгдсэн байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулав.



Харин төгрөгийн юаньтай харьцах дундаж ханш өмнөх сараас 1.5 хувиар суларч 365.2 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 361.7 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 370.8 төгрөг байлаа.

Төгрөгийн ханш юаны эсрэг суларса байна.



5. ХҮҮ

2018 оны 9 дүгээр сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувь, гадаад валютын хүү 0.2 нэгж хувиар тус тус буурч 11.4, 4.9 хувьд хүрчээ. Иргэдээс татсан төгрөгийн хадгаламж 11.8 хувь, хувийн байгууллагаас татсан хадгаламж 10.2 хувийн хүүтэй байна. Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ

Өмнөх он мөн үеэс 2.3 нэгж хувиар, гадаад валютын зээлийн хүү 1.8 нэгж хувиар тус тус буурч харгалзан 17.7 хувь болон 9.8 хувьд хүрчээ. Тайлант сард иргэдэд олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 18.3 хувь, гадаад валютын зээлийн хүү 9.5 хувьтай байгаа бол хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 17.1, валютын зээлийн хүү 9.8 хувьтай байна.

Шинээр татсан хадгаламжийн хэмжээ, хүү



Шинээр олгосон зээлийн хэмжээ, хүү



Хөгжлийн банкны хадгаламжийг оруулаагүй болно.


Тайлант сард шинээр татсан нийт төгрөгийн хадгаламжийн дийлэнхийг 7-9 хувь ба түүнээс дээш 12-15 хувьтай татсан байна.

Шинээр татсан нийт ₮-ийн хадгаламжийн хүүний тархалт



2018 оны 9 дүгээр сарын байдлаар шинээр олгосон зээлийн ЖДХ 14.9–20.4 хувийн хүүтэй байна.

Шинээр олгосон нийт ₮-ийн зээлийн хүүний тархалт




2018 оны 9 дүгээр сарын байдлаар төгрөгийн хадгаламжийн үлдэгдлийн ЖДХ 12.3 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурсан бол гадаад валютын хадгаламжийн хүү 5.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй байна. Тайлант сард иргэдийн хадгаламжийн үлдэгдлийн ЖДХ 12.3 хувь, гадаад валютын хүү 5.4 хувьтай байна. Тухайн сарын хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн ЖДХ 11.5 хувь, гадаад валютын хүү 5.5 хувь байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү



Нийт төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 17.5 хувь, гадаад валютын зээлийн хүү 10.7 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 18.6 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 12.9 хувьтай бөгөөд хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.6 хувь, гадаад валютын зээлийн хүү 10.6 хувьтай тус тус байна. Төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар, гадаад валютын зээлийн ЖДХ 0.7 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Нийт зээлийн үлдэгдэл, хүү



Хөгжлийн банкны хадгаламжийг оруулаагүй болно.


Тайлант сарын нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалтыг харвал, эдгээр хадгаламжийн дийлэнх нь 5,7 хувь ба түүнээс дээш 13-16 хувьтай байна.

Нийт ₮-ийн хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Харин нийт төгрөгийн зээлийн үлдэгдлийн дийлэнх нь 18 хувь ба түүнээс дээш 19-20 ба 22-24 хувьтай байна.

Нийт ₮-ийн зээлийн үлдэгдлийн хүүний тархалт



6. ИНФЛЯЦИ

Тайлант сард Улаанбаатар хотын жилийн инфляци 5.9 хувьд хүрч өмнөх сараас буурсан байна. Үүнээс 5.1 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 0.8 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд түрээс, хатуу түлш, автобензин, тээврийн үйлчилгээ, эм, тариа, тамхи болон их дээд сургуулийн үнийн өсөлт, харин хүнсний барааны бүлгийн үнэд будаа, цөцгийн тос, үхрийн махны үнийн өсөлт голлон нөлөөлжээ.

УБ хотын хэмжээнд сарын инфляци 0.01 хувьд хүрсэн байна. Өмнөх сараас үнийн түвшин буурахад хүнсний бараа -0.8 нэгж хувийг, хүнснээс бусад бараа 0.7 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Хүнсний барааны үнэ буурахад хүнсний ногооны үнийн бууралт болон хонины махны үнийн бууралт голлон бүрдүүлж байгаа бол хүнснээс бусад бараа өсөхөд хувцас болон орон сууцны түрээсийн үнийн өсөлт нөлөөлжээ.

УБ хотын жилийн инфляци 5.9 хувь



УБ хотын сарын инфляци -0.01 хувь



ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц



Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/




Зураг 2.3. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл тэрбум ₮



Зураг 2.4. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.5. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.6. Чанаргүй зээлийн дүн



Зураг 2.7. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбараар



Зураг 2.9 Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц



Зураг 2.10. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.11. Орон нутгийн зээлийн үлдэгдэл /тэрбум/



Зураг 2.11. Орон нутгийн чанаргүй зээлийн эзлэх хувь



3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр




Зураг 3.2. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар




Зураг 3.3. Улаанбаатар хотын ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.5. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он




Зураг 3.7. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт



Зураг 3.4. Орон нутгийн ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар



Зураг 3.6. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.8. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл

